



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар #148

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сант сумын Засаг даргын Тамгын газрын автомашины засварт 20,000,000 (хорин сая), Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын автомашины засварт 10,000,000 (арван сая), Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын автомашины засварт 3,000,000 (гурван сая) төгрөг, нийт 33,000,000 (гучин гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0101